



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын Засгийн
газрын тухай хуульд нэмэлт
оруулах тухай**

**Монгол Улсын
хууль**

**Татварын ерөнхий
хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын 2018 оны
төсвийн тухай**

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

560.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2138
561.	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2139
562.	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2140
563.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2140
564.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2141
565.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2143
566.	Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2149
567.	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2150
568.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2151
569.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2151
570.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2152
571.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2153
572.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2153
573.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2155
574.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2155



575.	Монгол Улсын 2018 оны төсвийн тухай		2157
576.	Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай		2255
577.	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай		2257
578.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2259
579.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай		2261
580.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай		2261
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
581.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 68	2262
582.	Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 69	2263
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр		Улаанбаатар хот	
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ			
<p>1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 15 дахь заалтад “- эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалт;” гэж нэмсүгэй.</p>			
<p>2 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>			
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА		М.ЭНХБОЛД	



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.4.9 дэх заалт:

“13.4.9.газар эзэмших, ашиглах эрхтэй хуулийн этгээд болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн мэдээлэл.”

2/18 дугаар зүйлийн 18.1.15 дахь заалт:

“18.1.15.хуульд заасан бусад адилтгах үүрэг.”

3/71¹ дүгээр зүйлийн 71¹.10, 71¹.11 дэх хэсэг:

“71¹.10.Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон, шилжүүлснийг бүртгэсэн талаархи мэдээллээ татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүр хүргүүлнэ.

71¹.11.Хуулийн этгээдийн улсын бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэл, эцсийн эзэмшигчийн бүртгэлийн өөрчлөлтийн мэдээллийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүр хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.1.14.газар эзэмших, ашиглах эрхтэй хуулийн этгээд болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн талаархи мэдээлэл, түүний өөрчлөлтийн тухай мэдээллийг шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор харьяа татварын албанд бүртгүүлэх.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь эцсийн эзэмшигчийн мэдээллээ 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, харьяа татварын албанд нөхөн бүртгүүлнэ.

2 дугаар зүйл. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээтэй хуулийн этгээд нь эцсийн эзэмшигчийн мэдээллээ 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор харьяа татварын албанд нөхөн бүртгүүлнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

“3.1.11. “эцсийн эзэмшигч” гэж өөрийн эзэмшиж буй хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн үндсэн дээр хуулийн этгээдийн хяналт, удирдлага, хөрөнгийг шууд, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдийн хувьцаа, хувь оролцоогоор төлөөлүүлэн удирдан чиглүүлж буй дараахь этгээдийг:

3.1.11.а. хуулийн этгээдийн хамгийн их саналын эрхийг эзэмшдэг;



3.1.11.б.хуулийн этгээдийн хувьцааны тоо, эсхүл зах зээлийн нийт үнэлгээний хамгийн ихийг эзэмшдэг;

3.1.11.в.адилтгах бусад.”

2/11 дүгээр зүйлийн 11.1.12 дахь заалт:

“11.1.12.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаархи мэдээлэл.”

3/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

“11.4.Энэ хуулийн 11.1.12-т заасан эцсийн эзэмшигчийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд холбогдох татварыг төлсөн талаархи татварын албаны тодорхойлолтыг үндэслэн өөрчлөлтийг бүртгэнэ.”

4/15 дугаар зүйлийн 15.2.10 дахь заалт:

“15.2.10.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд эцсийн эзэмшигч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаархи мэдээлэл.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт:

“4.1.8.“эцсийн эзэмшигч” гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3.1.11-т заасныг.”

**2/16 дугаар зүйлийн 16.11, 16.12, 16.13, 16.14 дэх хэсэг:**

“16.11.Энэ хуулийн 8.2-т заасан орлогыг тухайн эрх эзэмшигч, түүний эцсийн эзэмшигчийн шилжүүлсэн хувьцаа, хувь оролцооноос тухайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцаанд ногдох хэмжээгээр тусгай зөвшөөрлийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

16.12.Энэ хуулийн 8.2-т заасан орлогыг тухайн эрх эзэмшигч, түүний эцсийн эзэмшигчийн шилжүүлсэн хувьцаа, хувь оролцооноос тухайн газар эзэмших, ашиглах эрхтэй этгээдийн хувьцаанд ногдох хэмжээгээр газрын эрхийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

16.13.Энэ хуулийн 16.12-т заасан орлогыг Газрын тухай хуулийн 38.6-д заасан үнийн шаардлагыг үндэслэн тодорхойлох ба татварын ногдлыг тодорхойлох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.14.Энэ хуулийн 16.11-т заасан орлогод албан татвар ногдуулах аргачлал, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох аргачлалыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3/21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэг:

“21.7.Энэ хуулийн 16.11, 16.12, 16.13, 16.14-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулах албан татварыг тухайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл газар эзэмших, ашиглах эрхтэй этгээд хэлцэл хийгдсэнээс хойш ажлын 7 хоногийн дотор ногдуулан суутган авч, төсөвт шилжүүлнэ.”

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.2.Эрх борлуулсны орлогод дараахь орлогыг хамааруулна:

8.2.1.эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад шилжүүлснээс олсон орлого;

8.2.2.хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах



эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон орлого.”

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийн дугаарыг “21.8” гэж, 21.8 дахь хэсгийн дугаарыг “21.9” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/49 дүгээр зүйлийн 49.4.8 дахь заалт:

“49.4.8. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.14 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу тооцсон үнэ, тайлбар, танилцуулга.”

2/49 дүгээр зүйлийн 49.12 дахь хэсэг:

“49.12. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-т заасан эцсийн эзэмшигч ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шууд бусаар шилжүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 49.4.8-д заасан баримт бичгийг харьяа татварын албанд шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор мэдэгдэнэ.”

3/56 дугаар зүйлийн 56.1.9, 56.1.10, 56.1.11 дэх заалт:

“56.1.9. Энэ хуулийн 49.1, 49.2, 49.3-т заасныг зөрчиж тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн бол;

56.1.10. тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 49.4.8, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.11, 16.14-д



заасан аргачлалын дагуу холбогдох татварыг тайлагнаагүй, эсхүл үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан;

56.1.11.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11.1.12, 15.2.10, Татварын ерөнхий хуулийн 18.1.14-т заасны дагуу холбогдох байгууллагад үнэн зөв мэдээлээгүй бол.”

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний дараа “энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын журмаар” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтын “хайгуулын” гэсний дараа “болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “26.9” гэсний дараа “, 60.9-д” гэж, 49 дүгээр зүйлийн 49.6.1 дэх заалтын “шалтгаангүй” гэсний дараа “бөгөөд холбогдох татварыг төлсөн тухай татварын алба тодорхойлолт гаргасан” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11 дүгээр зүйлийн 11.1.25 дахь заалт:

“11.1.25.энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах.”

2/17 дугаар зүйл:

“17 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шалгаруулалтын талбайг ялгах

17.1.Энэ хуулийн 11.1.25-д заасны дагуу төрийн захиргааны байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд талбайн зургийг хавсаргана.

17.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, 45 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасан үндэслэлээр татгалзсан хариу өгч болно.



17.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг энэ хуулийн 17.2-т заасны дагуу ирүүлсэн зөвшөөрсөн санал болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

17.4.Энэ хуулийн 17.3-т заасны дагуу Засгийн газраас баталсан талбайн солбицлын хүрээнд төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялгаж, сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

17.5.Энэ хуулийн 17.4-т заасны дагуу ялгасан талбай нь дараахь шаардлагыг хангасан байна:

17.5.1.дөрвөн өнцөгт хэлбэртэй байх бөгөөд түүний хил нь уртраг, өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн байх;

17.5.2.тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар, нөөцөд авсан талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй байх;

17.5.3.хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй байх.

17.6.Энэ хуулийн 17.5.2, 17.5.3-т заасан давхцал гаргахгүйн тулд хүсэлтэд дурдсан талбайн дараахь газар нутаг, талбайтай хиллэж байгаа хэсэг нь шулуун шугам биш байж болно:

17.6.1.улсын хил;

17.6.2.нөөцөд авсан талбай;

17.6.3.тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар;

17.6.4.энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө олгогдсон тусгай зөвшөөрөлтэй бөгөөд энэ хуульд зааснаас өөр хэлбэр, байршил бүхий талбай;

17.6.5.хайгуулын талбайд хамруулах боломжгүй гэж үзсэн нуур, цөөрөм зэрэг байгалийн тогтоц.

17.7.Нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 150 мянган гектараас ихгүй байна.”

**3/18 дугаар зүйл:****“18 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх журам**

18.1.Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ энэ хуулийн 10.1.2-т заасан журмын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараахь баримт бичгийг хавсаргана:

18.1.1.тухайн хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, факсны дугаар, цахим шуудангийн хаяг;

18.1.2.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

18.1.3.үйлчилгээний хөлс төлсөн баримт;

18.1.4.мэргэжлийн боловсон хүчин болон техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан талаархи мэдээлэл, тухайн талбайд гүйцэтгэх хайгуулын ажлын төрөл, хэмжээ, хугацаа, өртөг болон байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулах зардал бүхий төсөл, төсөв болон холбогдох бусад баримт бичгийг нэгтгэсэн техникийн санал;

18.1.5.төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу үйлдэж, битүүмжилж ирүүлсэн үнийн санал;

18.1.6.Монгол Улсад татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай татварын албаны тодорхойлолт;

18.1.7.Энэ хуулийн 10.1.2-д заасан журамд заасан бусад шаардлагатай баримт бичиг.”

18.2.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 18.1-д заасан хүсэлтийг хүлээн авмагц доор дурдсан ажиллагааг явуулна:

18.2.1.хүсэлтийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг хүсэлт гаргасан этгээдэд өгөх;

18.2.2.тухайн өдөр хамгийн түрүүнд болон сүүлд бүртгэгдсэн хүсэлтэд тусгай тэмдэглэгээ хийх.”

4/20 дугаар зүйл:

“20 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох

20.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу зохион байгуулж, доор дурдсан ажиллагааны аль нэгийг гүйцэтгэнэ:

20.1.1.хүсэлт гаргасан хуулийн этгээдийн техникийн болон үнийн саналд энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу үнэлгээ өгч, хамгийн өндөр үнэлгээ авсан оролцогчид тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх;

20.1.2.хэрэв 2 болон түүнээс дээш оролцогч адил үнэлгээ авсан бол хүсэлтээ хамгийн түрүүнд бүртгүүлсэн оролцогчид тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх.

20.1.3.хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 18.1-д заасан шаардлага хангаагүй бол сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй үндэслэл, шалтгааныг хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн хамт хүсэлт гаргасан хуулийн этгээдэд хүргүүлнэ.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт зарласан боловч хүсэлт ирээгүй бол сонгон шалгаруулалтыг дахин зарлаж болно.

20.3.Энэ хуулийн 20.1.1, 20.1.2-т заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой бол сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мөн хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай мэдэгдлийг сонгон шалгаруулалтад шалгарсан хуулийн этгээдэд хүргүүлнэ.

20.4.Энэ хуулийн 20.3-д заасны дагуу мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд тусгай зөвшөөрлийг авах боломжгүй тухайгаа мэдэгдсэн, эсхүл сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, эхний жилийн төлбөрийг төлөөгүй бол төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.1.1, 20.1.2-т заасан мэдэгдлийг хүчингүй болгож, хүсэлт гаргасан хуулийн этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.



20.5. Сонгон шалгаруулалтад шалгарсан хуулийн этгээд эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлсөн бол төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдөрт багтаан хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

20.6. Хайгуулын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон талбайн булангийн цэгийн солбицлуудыг тэмдэглэх бөгөөд уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна.

20.7. Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.”

5/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:

“24.2. Энэ хуулийн 24.1-д зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохдоо энэ хуулийн 18 дугаар зүйл, 20.1-д заасан журмыг нэгэн адил баримтална.”

4 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын “энэ хуулийн 19.12,” гэснийг “улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбай болон энэ хуулийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалтын “хүссэн” гэснийг “олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг” гэж, 11¹ дүгээр зүйлийн 11¹.1.3 дахь заалтын “геологи, уул уурхай” гэснийг “үндэсний геологи” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “19.6” гэснийг “20.3” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “19.12,” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтын “үндэсний” гэснийг, 11.1.13 дахь заалтын “улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн эрдсийн хуримтлал бүхий талбайд” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалтын “шийдвэрлэх” гэснийг, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “, 24.2” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “, 24.2” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.



7 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг:

“33.5.Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж олгоно.”

2/38 дугаар зүйлийн 38.2.4 дэх заалт:

“38.2.4.татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай цахим эсхүл хэвлэмэл тодорхойлолт.”

3/38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг:

“38.6.Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн бол орлого олсон гэж үзэж, орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцно.”

4/40 дүгээр зүйлийн 40.1.7 дахь заалт:

“40.1.7.газар эзэмших эрхтэй этгээд нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.13, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 20.1.6, 22.1.5-д заасны дагуу холбогдох татварыг тодорхойлж тайлагнаагүй, үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан.”



5/44 дүгээр зүйлийн 44.10 дахь хэсэг:

“44.10.газар ашиглах эрхтэй этгээд нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.13, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 20.1.6, 22.1.5-д заасны дагуу холбогдох татварыг тодорхойлж тайлагнаагүй, үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан бол газар ашиглах эрхийн гэрчилгээ болон газар ашиглах гэрээг цуцалж, ашиглалтын явцад учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.”

2 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.3 дахь заалтын “хураамж” гэсний өмнө “албан татвар,” гэж, 44 дүгээр зүйлийн 44.8 дахь хэсгийн “33.2” гэсний дараа “33.5” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН
ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ
НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “2018” гэснийг “2019” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“34.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4.1 дэх хэсгийн “Эрүүл мэндийн даатгалын сан,” гэснийг, 5.4.36 дахь заалт, 6.2.10 дахь заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, 4.1 дэх хэсгийн “Ирээдүйн тэтгэврийн нөөц сан,” гэснийг, 5.4.39 дэх заалт, 6.2.12 дахь заалтыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалт:

“6.2.6.Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахаар бол доор дурдсан зохицуулалт хийнэ:

6.2.6.а.тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх;

6.2.6.б.төсөвт төвлөрүүлэх татвар болон төлбөрийн хэмжээг бууруулах бол мөн хэмжээгээр зардлыг бууруулах.”



2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“71.5.Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.6 дахь хэсэг, мөн зүйлийн 8.6.3 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн,” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв”, гэснийг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн” гэснийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн,” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.8, 8.9 дэх хэсгийн “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэснийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, 8 дугаар зүйлийн 8.4, 8.6 дахь хэсэг, мөн зүйлийн 8.6.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.8, 8.9 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “болон Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

5 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.”



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Хүүхэд хамгааллын тухай,” гэсний дараа “Сургуулийн өмнөх боловсролын тухай, Боловсролын тухай,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн “Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын” гэснийг “Боловсролын” гэж, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн” гэснийг “боловсролын” гэж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “хүүхэд, гэр бүлийн” гэснийг “боловсролын” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн” гэснийг “боловсролын асуудал хариуцсан” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

**1/8 дугаар зүйлийн 8.1.10 дахь заалт:**

“8.1.10.бусдаас үнэ төлбөргүй авсан газар эзэмших, ашиглах эрхийн орлого.”

2/14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт:

“14.1.4.газар эзэмших, ашиглах эрх борлуулсны орлого. Борлуулалт гэдэгт тухайн газар эзэмших, ашиглах эрхийг өөр төрлийн хөрөнгө, үйл ажиллагаагаар харилцан солилцохыг мөн ойлгоно.”

3/16 дугаар зүйлийн 16.1.19 дэх заалт:

“16.1.19.Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээдүүд хоорондоо газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон энэ хуулийн 8.1.10-т заасан орлого.”

4/20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт:

“20.1.6.газар эзэмших, ашиглах эрх борлуулсны орлогыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.13-т заасан аргачлалаар тогтоосон дүнгээр;”

5/22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт:

“22.1.5.бусдаас үнэ төлбөргүй авсан газар эзэмших, ашиглах эрхийн орлогыг Татварын ерөнхий хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу шууд бус аргаар тодорхойлсон дүнгээр.”

6/23 дугаар зүйлийн 23.2.6 дахь заалт:

“23.2.6.энэ хуулийн 20.1.6, 22.1.5-д заасан орлогын дүнд 10 хувиар.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.11, 25.12 дахь хэсэг нэмсүгэй:

“25.11.Байнгын хороо, дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед нам, эвслийн бүлэг, гишүүдийн гаргасан санал нь Төсвийн тухай хуулийн 6.2.6 дахь заалтад нийцсэн байна.

25.12.Хоёр дахь хэлэлцүүлгийн үед нам, эвслийн бүлэг, гишүүд, Ерөнхийлөгч, Төрийн аудитын төв байгууллага тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах, түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гаргаж, нэг санал болгон санал хураалт явуулна.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн “25.11, 25.12, 25.13, 25.14, 25.15, 25.16, 25.17” дахь хэсгийн дугаарыг “25.13, 25.14, 25.15, 25.16, 25.17, 25.18, 25.19” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай 15¹ дүгээр зүйл нэмсүгэй:



“15¹ дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, түүний удирдлага

15^{1.1}. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд эрүүл мэндийн даатгалын орон нутгийн салбар, нэгж нь эрүүл мэндийн даатгалын байгууллагын удирдлагын доор үйл ажиллагаа явуулна.

15^{1.2}. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын даргыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

15^{1.3}. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан байна.

15^{1.4}. Эрүүл мэндийн даатгалын орон нутгийн салбарын даргыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад гурваас доошгүй жил ажилласан ажилтнаас сонгон шалгаруулж, эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14^{1.5} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14^{1.5}. Үндэсний зөвлөл ажлын албатай байна.”

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.8 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6, 7.2.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, мөн зүйлийн 21.5.1, 21.5.2 дахь заалтын “нийгмийн даатгалын байгууллага” гэснийг “эрүүл мэндийн даатгалын байгууллага” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1, 22.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1, 23.3 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын байгууллага” гэснийг “Эрүүл мэндийн даатгалын байгууллага” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтын “нийгмийн даатгалын байгууллагатай” гэснийг “эрүүл мэндийн даатгалын байгууллагатай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын байгууллагатай” гэснийг “Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийн “нийгмийн даатгалын байгууллагаас” гэснийг “эрүүл мэндийн даатгалын байгууллагаас” гэж, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн «эрүүл мэндийн даатгалын болон» гэснийг «нийгмийн даатгалын болон» гэж, 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, 21



дүгээр зүйлийн 21.5.1 дэх заалтын “нийгмийн даатгалын байгууллагад” гэснийг “эрүүл мэндийн даатгалын байгууллагад” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.8.1, 14.9.1, 14.9.2 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.5, 20.1.6 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсгийн “нийгмийн даатгалын байгууллагын” гэснийг “эрүүл мэндийн даатгалын байгууллагын” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 14¹ дүгээр зүйлийн 14¹.6 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, 21.5.2, 21.5.3 дахь заалтын “нийгмийн даатгалын асуудал” гэснийг “эрүүл мэндийн даатгалын асуудал” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “сумын нийгмийн даатгалын” гэснийг “сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан” гэж, 16 дугаар зүйлийн гарчгийн “Нийгмийн даатгалын байгууллагын” гэснийг “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын” гэж, 17 дугаар зүйлийн гарчиг, 17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 18.1, 18.3, 18.4 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын улсын” гэснийг “Эрүүл мэндийн даатгалын улсын” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын байгууллагад” гэснийг “Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтын “нийгмийн даатгалын байгууллагаар” гэснийг “эрүүл мэндийн даатгалын байгууллагаар” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.3 дахь заалтын “6.1.5, 6.1.9” гэснийг “6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.9, 6.1.12” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг,



Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв сангаас улсын төсөвт олгох шилжүүлэг болон улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль², энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Их Хурлын дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,684.9 2,684.9
2	Монгол Улсын Ерөнхий Аудитор Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	87.6 87.6
3	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	60.0 60.0
4	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	822.4 822.4
5	Үндэсний статистикийн хорооны дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	24.4 24.4
6	Монгол Улсын Ерөнхий сайд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Үүнээс: Ирээдүйн өв санд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	182,092.9 3,000.0 175,616.1 47,842.5 3,476.8

¹Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

²Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.



7	Улсын ерөнхий прокурор Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	300.2 300.2
8	Монгол Улсын Шадар сайд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Стандарт, хэмжил зүйн газар Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	12,129.7 2,600.0 2,734.6 2,006.0 4,789.1
9	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	407.7 265.2 142.5
10	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	10,274.9 9,979.4 295.5
11	Гадаад харилцааны сайд Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	21,150.0 19,600.0 1,550.0
12	Сангийн сайд Татварын ерөнхий газар Үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Ирээдүйн өв санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,669,220.5 2,375,776.2 122,747.2 460,901.8 2,194,165.1 13,229.3 71,559.7 10,916.7 3,573.5
13	Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	63,695.9 18,000.0 3,487.5 20,600.7 625.5 5,481.4 15,500.8
14	Батлан хамгаалахын сайд Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	51,794.1 6,593.4 45,200.7
15	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	61,695.6 56,969.1 4,726.6
16	Зам, тээврийн хөгжлийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн хөгжлийн яам	170,952.2 167,672.8 209.0



	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	920.4 2,150.0
17	Барилга, хот байгуулалтын сайд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,158.4 1,815.2 343.2
18	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ашигт малтмал, газрын тосны газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	299,286.4 291,808.1 7,478.3
19	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	199,203.8 115,491.0 1,414.6 82,298.2
20	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	63,435.8 550.0 631.1 9,513.7 52,741.0
21	Эрүүл мэндийн сайд Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	239,438.9 201,802.1 8,269.5 29,367.3
22	Эрчим хүчний сайд Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	4,016.0 4,016.0

4 дүгээр зүйл. Монгол Улсын төсөвт 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 5,207,337.2 сая төгрөгөөр баталсугай.

5 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	5,241.0 4,470.3 770.7
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	33,113.2 28,514.9 1,913.3 2,684.9



3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	2,033.0 1,693.0 340.0
4	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Урсгал зардал	3,998.1 3,998.1
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Урсгал зардал	48,604.8 48,604.8
6	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Урсгал зардал	1,140.6 1,140.6
7	Улсын ерөнхий прокурор Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	29,238.0 28,485.8 452.0 300.2
8	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Урсгал зардал	2,055.9 2,055.9
9	Монгол Улсын Ерөнхий аудитор Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	11,530.5 10,942.9 500.0 87.6
10	Авлигатай тэмцэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	14,845.5 14,649.9 195.6
11	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Урсгал зардал	3,834.7 3,834.7
12	Төрийн албаны зөвлөлийн дарга Урсгал зардал	730.8 730.8
13	Үндэсний статистикийн хорооны дарга Урсгал зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	9,487.7 9,463.3 24.4
14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Урсгал зардал	1,139.0 1,139.0
15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Урсгал зардал	647.6 647.6
16	Монгол Улсын Ерөнхий сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	203,278.4 98,058.6 94,458.4 10,761.4
17	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	136,729.3 113,203.4 14,086.2 9,439.7



18	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	33,531.3 13,621.8 11,881.8 8,027.7
19	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	88,160.0 57,375.6 20,717.5 10,067.0
20	Гадаад харилцааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	71,730.8 69,930.8 1,800.0
21	Сангийн сайд Урсгал зардал Дотоод эх үүсвэрээс олгох зээл Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт	6,353,791.1 1,540,075.0 136,104.3 32,810.0 152,167.1 4,232,825.8 259,808.9
22	Хууль зүй, дотоод хэргийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	476,978.7 428,191.1 37,390.0 11,397.6
23	Зам, тээврийн хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	384,534.6 9,234.6 80,796.9 294,503.0
24	Батлан хамгаалахын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	237,063.9 233,464.4 3,599.5
25	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Урсгал зардал Үүнээс: Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг Соёлын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг Нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг Дотоод эх үүсвэрээс олгох зээл Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	1,632,349.0 1,136,445.0 311,267.4 619,730.0 45,245.0 12,647.8 96,800.0 262,817.6 136,286.4

26	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	26,397.1 9,081.2 17,315.9
27	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Урсгал зардал Дотоод эх үүсвэрээс олгох зээл Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	266,633.8 107,643.8 97,778.7 50,218.5 10,992.8
28	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Урсгал зардал Үүнээс: Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг Хөрөнгийн зардал Дотоод эх үүсвэрээс олгох зээл Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	1,267,659.9 1,201,772.2 6,331.8 17,340.0 22,900.0 25,647.8
29	Эрүүл мэндийн сайд Урсгал зардал Үүнээс: Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	766,306.1 632,971.2 113,313.1 60,754.8 72,580.1
30	Эрчим хүчний сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	161,046.4 19,498.0 37,661.9 103,886.4
31	Барилга, хот байгуулалтын сайд Урсгал зардал Үүнээс: Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	137,233.3 15,131.3 10,559.4 80,338.4 41,763.6

6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2018 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 7,710,777.6 сая төгрөгөөр баталсугай.

